



БАЯНЦАГААН СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА, ТУСГАЙ САНГУУД 2013 оны САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан
Аймгийн Ерөнхий аудитор
өрөөний утас 70272582

Т.Майцэцэг - Ахлах аудитор
өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Баянцагаан сумын 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Баянцагаан сумын 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянцагаан сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

**Гол санхүүгийн хяналтууд
хамрагдсаныг тодруулбал:**

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

**Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр
дүнгээс гарсныг торуулбал:**

- Орон нутгийн төсвийн татварын орлогыг 15242.3 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 17616.9 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 674.5 мянган төгрөгөөр буюу 104.0 хувиар давуулан биелүүлсэн байна.
- Орон нутгийн орлогын дансны үлдэгдэл 13443.3 мянган төгрөгийн 6600.0 мянган төгрөг нь урьд оны хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн үлдэгдэл санхүүжилт ба 6843.3 мянган төгрөг нь орон нутгийн төсвийн орлого байна.
- Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 291922.5 мянган төгрөг, Цэцэрлэгт 66915.5 мянган төгрөг, Эмнэлэгт 194244.2 мянган төгрөг, Соёлын төвд 37995.9 мянган төгрөг, нийт 591078.1 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон ба жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 5712.1 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна
- Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 36006.2 мянган төгрөг нэгдсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагат дамжуулах

үүргээр хийгдсэн 17580.5 мянган
төгрөгийн алдааг залруулж 18425.7
мянган төгрөг болгон нэгтгэсэн .

•

*ЕМ, Санхүүгийн албанаас ҮАГазрын
харьяа Төв аймгийн Аудитын Газар
тайлбар мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн
алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар
ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж
авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх
зөрчлүүд материаллагын урьдчилан
тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй
санал дүгнэлт гаргахаар **Ерөнхий**
аудитор т санал оруулсан
байгаа

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газрын дарга, Тэргүүлэх Аудитор
2014.03.22-ны өдөр санал дүгнэлтэнд
гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч,
нярав болон бусад албан тушаалтан
бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд
дэмжлэг болж байсанд гүнээ талархаж
байна.

ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

2014.03.20

Танилцуулга

Баянцагаан сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянцагаан сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Баянцагаан сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Баянцагаан сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Баянцагаан сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 15242.3 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХУрлын 2013.12.16-ний өдрийн 06-р тогтоолоор сумын орон нутгийн төсвийн орлогыг 1700.0 мянган төгрөгийг суутган-2-т тодотгон 16942.3 мянган төгрөг болгон тодотгосон байна. Тайлант онд гүйцэтгэлээр 17616.9 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 674.5 мянган төгрөгөөр буюу 104.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 53.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд орлогын 1003762.1 мянган төгрөгийн, зарлагын 990372.3 мянган төгрөгийн гүйлгээ хийгдэж жилийн эцэст 13443.3 мянган төгрөгийн үлдэгдэл орон нутгийн төсвийн 140700910 тоот дансанд байна. Үлдэгдлийн 6600.0 мянган төгрөг нь урьд оны хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн үлдэгдэл санхүүжилт ба 6843.3 мянган төгрөг нь орон нутгийн төсвийн орлого байна. Үүнд:

Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 17616.9 мянган төгрөг төвлөрсөн ба НҮҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 258364.8 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 591078.1 мянган төгрөг, ОНХСанд аймгийн төсвөөс 143539.4 мянган төгрөг,

урьд оны хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн үлдэгдэл санхүүжилт аймгийн төсвөөс 10779.8 мянган төгрөг, нийт 1003762.1 мянган төгрөг төвлөрсөн байна.

Төрийн сангийн шилжүүлгээр санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 171469.1 мянган төгрөг, ИТХуралд 33517.7 мянган төгрөг, Багт 44378.0 мянган төгрөг нийт 249364.8 мянган төгрөгийн санхүүжилтийг, Орон нутгийн төсвөөс ЗДТГазар 8675.0 мянган төгрөг, ИТХурал 1000.0 мянган төгрөг, Баг 1100.0 мянган төгрөг, нийт 10775.0 мянган төгрөгийг олгосон байна. БХСанд 9000.0 мянган төгрөг, ОНХСанд 143539.4 мянган төгрөг тус тус олгогдсон байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 291922.5 мянган төгрөг, Цэцэрлэгт 66915.5 мянган төгрөг, Эмнэлэгт 194244.2 мянган төгрөг, Соёлын төвд 37995.9 мянган төгрөг, нийт 591078.1 мянган төгрөг шилжүүлсэн ба дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 5712.1 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Халамжийн сангийн санхүүжилт 122147.0 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 97219.1 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 22262.9 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 1980.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 685.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 18425.7 мянган төгрөг, Сургууль 1043.2 мянган төгрөг, ЭМТөв 670.0 мянган төгрөг, Соёлын төв 477.0 мянган төгрөг нийт 38196.4 мянган төгрөгийг орлого, зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан. ЗДТГазарт 18425.7 мянган төгрөгийг 36006.2 мянган төгрөгөөр нэгтгэсэнийг аудитын явцад залруулсан

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 52.8 мянган төгрөг, Соёлын төв 80.0 мянган төгрөг, ЭМТөв 263.5 мянган төгрөг нийт 396.3 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Сум Хөгжлийн Санд 50000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангийн данснаас төвлөрсөн сумын төрийн сангаар гүйлгээ хийгдээгүй байна

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 11072.6 мянган төгрөг, ИТХурал 233.0 мянган төгрөг, Баг 178.7 мянган төгрөг нийт 11484.3 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 82827.6 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 53.5 мянган төгрөг, эм эргэлтийн сан 789.7 мянган төгрөг нийт 95155.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 78414.7 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 13443.3 мянган төгрөг, эм эргэлтийн сан 1233.5 мянган төгрөг нийт 93091.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгааатай тохирч байна.

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 117558.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 152014.6 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 162839.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 106733.2 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 2933569.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 193103.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 149512.9

мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 2977159.9 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 119971.2 мянган төгрөг үлдэх өртөг 1847602.2 мянган төгрөг байна

Авлага, өглөг

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 93237. мянган төгрөгийн авлага, 1350.7 мянган төгрөгийн өглөгтэй ба оны эцэст 218720.8 мянган төгрөгийн авлагатай, 1729.8 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. 2013 оны жилийн эцсийн нийт авлагын 198983.6 мянган төгрөгийн буюу 91 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн Хөгжлийн санд 143539.4 мянган төгрөгийн санхүүжилт, 80.0 мянган төгрөгийн тендерийн бичиг баримтын үнэ нийт 143619.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Үүнээс 110090.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст харилцах дансандаа 32728.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Үлдэгдэл Төрийн сангийн үлдэгдлийн баталгаатай тохирч байна. 800.0 мянган төгрөгийг П.Шийтэрцэрэнд илүү шилжүүлснийг авлагаар тайлагнасан ба 2014 оны 1-р сарын 8-нд авлагыг барагдуулсан байна. Тус сум нь тайлант онд 200034.4 мянган төгрөгийн 14 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс гүйцэтгэлээр 110890.6 мянган төгрөгийг олгосон байна. Үүнд:

- Сумын наадмын зардалд 5000.0 сая төгрөгийг сумын Засаг даргын захирамжаар зарцуулсан
- Ахуйн үйлчилгээний барилгын засварыг Гүүд Кэстл ХХК шалгарч 57254.6 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарч ажил гүйцэтгэх гэрээг 2013.08.05-ний өдөр байгуулсан ба гэрээнд ажил дуусах хугацаа 2013.09.10-ний өдөр дуусахаар байгуулсан. Ажил одоог болтол дуусаагүй хүлээж аваагүй ба нийт санхүүжилтийн 70 хувь буюу 40078.2 мянган төгрөгийг олгосон ба 1200.0 мянган төгрөгийг төсөвчин Дугармаад шилжүүлж 15976.4 мянган төгрөгийн дутуу үлдэгдэлтэй байна.
- Наадмын ширээний засварт Гүүд Кэстл ХХК-ийг мөн шалгаруулж 14280.8 мянган төгрөгийн гэрээ байгуулж ажлыг хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна.
- Орлого багатай иргэдэд халамж сургалтын хөтөлбөрт 10000.0 мянган төгрөгөөр батлагдсанаас 4 хүүхдэд 3990.0 мянган төгрөгийг оюутны сургалтын төлбөрт, ахмад настанд 30 иргэнд 100.0-500.0 мянган төгрөг буюу эмзэг бүлгийн 1 хүнд 1500.0 мянган төгрөгийн гэр нийт 6000.0 мянган төгрөгийг олгосон байна. Иргэдийн санаачлагыг дэмжин сумын Засаг даргын захирамжаар олгосон байна.
- НЭМТөвд хог түр хадгалах байрыг 1500.0 мянган төгрөгөөр хийхээр батлагдсанаас 750.0 мянган төгрөгийг олгож ажил нь хүлээлгэж өгөөгүй тул 750.0 мянган төгрөг олгогдоогүй байна. Гүйцэтгэгч иргэн Д.Нэмэхбаатар
- Хогны машиныг 18880.0 мянган төгрөгөөр авч ЗДТГазарт хөрөнгөнд бүртгэсэн
- Гэрэлтүүлэгт 9314.0 мянган төгрөг, хүүхдийн тоглоомын талбайг 9785.0 мянган төгрөг хийгдэхээс ажил дуусаагүйгээс 30-50 хувийг олгож 11412.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна
- Худаг засварт 10 хүнд тус бүрт 1.0 сая төгрөг буюу 10.0 сая төгрөг олгохоос 8.7 сая төгрөгийг олгосон

- Машины засварт 4000.0 мянган төгрөг олгохоос 3999.9 мянган төгрөг зарцуулсан байна

ГХУССангийн талаар:

Мөнгөн хөрөнгө: Тайлант хугацаанд тус сангийн харилцах дансны эхний үлдэгдэл 1189.2 мянган төгрөг байсан ба тайлант онд ИТХурлын гэмт хэргийн урьдчилан сэргийлэх зардлаас 1016.2 мянган төгрөгийн орлого төвлөрч 2071.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн оны эцэст 134.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Авлага, өглөг бараа материалын үлдэгдэл байхгүй байна.

Мал хамгаалах сангийн талаар:

Мөнгөн хөрөнгө: Тайлант хугацаанд мал хамгаалах сангийн харилцах дансны эхний үлдэгдэл 5680.9 мянган төгрөг байсан ба тайлант онд 20231.5 мянган төгрөг төвлөрч 6568.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна. Үүнд:

Орлогыг нэр төрлөөр задалхад өвс тэжээлийн орлого 2639.8 мянган төгрөг, оторчдоос авсан татвар 1471.7 мянган төгрөг, ус зөөлрүүлэх төхөөрөмжийн санхүүжилт 2300.0 мянган төгрөг, малжуулах зээлийн төлөлт 13820.0 мянган төгрөг нийт 20231.5 мянган төгрөг байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар тээвэр шатахуунд 3649.9 мянган төгрөгийн, тавилга эд хогшилд 2644.0 мянган төгрөгийн нийт 6568.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст харилцах дансандаа 19343.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. ЗГазрын 197-р тогтоолын дагуу тус суманд 2010 оны 11-р сарын 11-ний өдрийн аймгийн Засаг даргын 545 тоот захирамжаар 35 иргэнд 59500.0 мянган төгрөгийн зээл олгосон зээлийн эргэн төлөлт 35 иргэнээс 23800.0 мянган төгрөг төвлөрөхөөс 13820.0 мянган төгрөг төвлөрч 9980.0 мянган төгрөг дутуу төвлөрсөн байгаад албан шаардлага бичих. Нэрсээр гаргаж ирүүлэх

Зарлагыг түүвэрлэн шалгахад: сумын Засаг даргын 2013.05.03-ний өдрийн А/60 тоот захирамжаар 344.0 мянган төгрөгийг сумын ЭМТөвийн шаардлагатай багаж төхөөрөмж авахад зарцуулж сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

сумын Засаг даргын 2013.05.03-ний өдрийн А/102 тоот захирамжаар, ажлын хөдөлмөрөөрөө тэргүүлсэн 5 малчинд 125.0 мянган төгрөг, ХХААхуйн тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан 3 хүнд 60.0 мянган төгрөг нийт 185.0 мянган төгрөг

сумын Засаг даргын 2013.11.26-ний өдрийн А/159 тоот захирамжаар ҮХААЯамны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан 2 хүнд 40.0 мянган төгрөг, ҮХААЯамны жуух бичгээр шагнагдсан 3 хүнд 30.0 мянган төгрөг, аймгийн хүндэт тэмдгээр шагнагдсан 1 хүнд 20.0 мянган төгрөг нийт 90.0 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Тус сангаас зарцуулсан шатахууны тайлан, замын хуудасны тооцоог тухай бүрд нь хийсэн байна.

Авлага: ХХААЖДҮГазрын даргын 2012.10.30-ний өдрийн А/21 тоот тушаалаар Цөөн малтай малчдыг малжуулах төслийн сонгон шалгаруулалтаар тус сумаас шалгарсан 7 малчинд тус бүрт 2.5 сая төгрөгийн зээлийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосоныг тус газрын даргын 2013.12.23-ний өдрийн 508 тоот албан бичгээр сумын МХСангийн данс бүртгэлийн дансанд тусган биелэлтэнд хяналт тавихыг мэдэгдсэн байна. Үүний дагуу 17500.0 мянган төгрөгийг оны эцэст авлагаар тайлагнасан байна. Төсөлд хамрагдсан зээлийн графикаар 2015 оны 6-р сард 30% буюу 750.0 мянган төгрөг, 2016 оны 6-р сард 30% буюу 750.0 мянган төгрөг 2015 оны 6-р сард 40% буюу 1000.0 мянган төгрөг төлөгдөх болно.

Бараа материал: Хангамжийн материал дансны эхний үлдэгдэл 11731.0 мянган төгрөг байсан ба оны эцэст 9091.2 мянган төгрөг тайлагнасан. Бараа материалын тайлан, тооцоо бодсон актаар 2639.4 мянган төгрөгийн бараа зарлагдсан ба 9091.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 5

нэр төрлийн өвс тэжээл байна. Өвс тэжээлийг дансны үнээр худалдсан ба үнийг бүрэн төвлөрүүлсэн байна

Сум хөгжүүлэх сангийн талаар:

Сум хөгжүүлэх сан нь оны эхэнд 67320.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба санхүүгийн дэмжлэг 50000.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэн ба зээл, зээлийн хүүний эргэн төлөлтөөс 22516.1 мянган төгрөг нийт 72516.1 мянган төгрөг төвлөрсөн ба 127313.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 12523.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Байдлын тайлангаар **Авлага** оны эхэнд 89303.8 мянган төгрөгийн, оны эцэст 198983.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 23 хүнтэй холбоотой 70.0 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн нь нийт авлагын 35 хувийг эзэлж байна.

Тайлант онд 65 иргэнд 132.0 сая төгрөгийн зээлийг олгосон.

Байгаль хамгаалах сангийн талаар:

БХСан нь оны эхэнд харилцах дансандаа 4521.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд аймгийн төсвөөс 9000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 5602.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 7919.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Үлдэгдэл Төрийн сангийн үлдэгдлийн баталгаатай тохирч байгаа боловч баталгааг ня-бо гаргаж гарын үсэг зурсан ба дарга, ТСангийн төлөөлөгч гарын зурж баталгаажуулаагүй байна. Авлага, өглөг бараа материалын үлдэгдэл байхгүй байна. Сангийн Зарлагын гүйлгээг шалгахад: БОУБайцаагчид компьютер принтер, зургийн аппаратыг 1247.0 мянган төгрөгөөр, хогийн савыг 3 ширхэг хогийн сав 800.0 мянган төгрөгөөр худалдан авч хөрөнгийг ЗДТГазарт орлогдсон байна. Хог цэвэрлэх зардалд 2811.1 мянган төгрөгийг зарцуулж тайлагнаж тооцоо бодсон анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн байна.

Байгаль орчин нөхөн сэргээлтийн сангийн талаар:

БОНССан нь оны эхэнд харилцах дансандаа 4115.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 1650.0 мянган төгрөгийн орлого Баянжонш ХХК –аас 300.0 мянган төгрөг, Винчон ХХК-аас 1250.0 мянган төвлөрч оны эцэст 5765.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Үлдэгдэл Төрийн сангийн үлдэгдлийн баталгаатай тохирч байна. Зарлагын гүйлгээ хийгдээгүй байна

Эм эргэлтийн сангийн талаар:

Эм эргэлтийн сангийн харилцах данс ХААН банкинд байршиж гүйлгээ хийгддэг. Тус сан нь оны эхэнд 789.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст 1233.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулах
- Бага оврын зуухны норм нормативыг мөрдөж ажиллах
- МУ-ын ЗГазрын 2012.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд илэрсэн ЗДТГазарт 17580.5 мянган төгрөгийн алдааг залруулсан болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.21